

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2017 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

“Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын Хавсралт
(Төрийн жинхэнэ албан хаагч – Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх)-г үнэлж дүгнэх Үлгэрчилсэн загвар)

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ (Илтгэх хуудас)

НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

1.1.Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан тусгай арга хэмжээнээс бусад **22 нийт арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1	2	3
22 арга хэмжээ	0-30	29,1

1.2.Гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон **10 тусгай арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 2

Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1	2	3
10 арга хэмжээ	0-40	38,3

1.3. **Манлайллын зорилт (орц)** бүрийн биелэлтийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 3

Манлайллын зорилт (орц)-ын тоо	Өгвөл зохих	Өгсөн оноо
--------------------------------	-------------	------------

	ОНОО	/дундаж оноо/
1	2	3
5 арга хэмжээ	0-30	30

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт /өөрийгөө хөгжүүлэх/-ын **биелэлт**:

.....

.....

.....

1.5. Тухайн төсвийн шууд захирагчийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой **хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажилласан** тухай **дүгнэлт**:

.....

.....

.....

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт:

.....

.....

.....

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

Гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1.Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт	0-30	29,7
2.Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	0-40	38,2
3.Манлайллын зорилт (орц)-ын биелэлт	0-30	30
Нийт оноо	0-100	97,9

3.2.Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээгээ гэж тэмдэглэнэ.

Хүснэгт 5

"А" буюу "Маш сайн"	"В" буюу "Сайн"	"С" буюу "Хангалттай"	"D" буюу "Дутагдалтай"	"F" буюу "Хангалтгүй"
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

--	--	--	--	--

Хэрэв "А" буюу "Маш сайн", эсхүл "D" буюу "Дутагдалтай", "F" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ:

.....

4.Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1).....

.....

2).....

.....Г.М.

5.Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт:

5.1.Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА /Г.БАТСУУРЬ /
 (албан тушаал) (гарын үсэг)

(тэмдэг)

.....
 (огноо)

5.2.Үнэлгээтэй танилцсан:

Төсвийн шууд захирагч

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Л.МӨНГӨНЦЭЦЭГ /
 (албан тушаал) (гарын үсэг)

(тэмдэг)

.....
 (огноо)

4216129408
 УСА0038 9018719

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2017 ОН/

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
<p align="center">Нэг. “Статистикийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:</p>		
<p>Арга хэмжээ -1.1. хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж мөрдүүлнэ. 1.1.1 Статистикийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. 1.1.2. Статистикийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллана.</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, олон нийтэд сурталчлах чиглэлээр ажлаа зохион байгууллаа. Хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлын хүрээнд: 1.Статистикийн хэлтэст 2017 оны мэдээ, судалгааны хүрээгээр мэдээлэл өгч буй иргэн ,аж ахуйн нэгж байгууллагуудын статистикийн хууль, дүрэм, журмын мэдлэгийг дээшлүүлэхээр сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх, зөвлөмж өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна. Хэлтсээс зохион байгуулсан 9 удаагийн сургалтад 224 хүнийг хамруулж , Статистикийн тухай хууль, Байгууллагын болон, хувь хүний нууцын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар хичээл заасан. 46 мэдээлэгч байгууллагад Статистикийн тухай хуулийн 9-р зүйл “Статистикийн мэдээлэгчийн эрх, үүрэг”-ийн талаарх зөвлөмжийг 1-р улиралд багтаан хүргүүлсэн. Мөн нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэд, АХС-д хамрагдсан өрхийн гишүүд, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, төрийн албан хаагчдад хуулийн нугалбар хийж хүргэх, сурталчлах ажлуудыг зохион байгуулж 3-4 удаагийн давтамжтайгаар 176 иргэнд зөвлөмж өгч,сурталчилгаа хийж</p>	

	<p>ажилласан байна.</p> <p>Нийтдээ хуулийн талаархи сургалт, сурталчилгаа, зөвлөмжид давхардсан тоогоор 405 иргэн, ААНБ хамрагдсан байна.</p> <p>Хэлтсийн дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, улсын байцаагчийн хяналт, шалгалтын төлөвлөгөө зэргийг гарган хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулж, илэрсэн зөрчийг арилгуулж ажиллаж байна. Улсын байцаагчийн хяналт, шалгалтыг 6 байгууллагад хийж, давхардсан тоогоор 73 зөрчил илрүүлж 100% арилгуулж ажилласан. Мөн графикийн дагуу ирж буй мэдээг шалган хүлээн авч, зөрчил гаргасан 17 байгууллагад алдааны протокол хүргүүлж ажилласан. Дотоод хяналт шалгалтыг хэлтсийн үйл ажиллагаа, сумдын статистик мэдээний чанарт хийж илэрсэн зөрчлийг тухай бүрд арилгуулахаар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Статистикийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр</p> <p>Хууль, Статистикийн хууль, дүрэм, журмуудыг байгууллагын govsumber.nso.mn цахим хуудсанд байршуулан сурталчлахаас гадна сум, багийн Засаг дарга нар, төрийн сангийн мэргэжилтнүүдийг хамруулан фейсбүүк хуудас нээн мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.</p>	28
<p>1.3.Тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах;</p> <p>1.3.1. Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал болон эрх бүхий этгээдээс гаргасан бусад эрх зүйн актын биелэлтийг хангаж ажиллана.</p> <p>1.3.2. ҮСХ-ны даргын тушаал, чиглэл, үүрэг даалгавар болон холбогдох газраас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллана.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 88 тоот зарлиг, Засгийн газрын 143,147-р тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврыг биелүүлж ажилласан.</p> <p>Байгууллагын “Ил тод , нээлттэй байдлыг хангах төлөвлөгөө”-г гарган мөрдөж ажиллаж байна. /тайланг хавсаргав/</p> <p>Төсвийн хэмнэлтийг эрхэмлэн батлагдсан орон тоо, цалин сангийн хязгаарт багтаан үйл ажиллагаагаа эрхэлж байна. Дотоод албан томилолтын замын зардлыг нийтийн тээврийн жишгээр олгож, суудлын авто машиныг нэн шаардлагатай ажил үйлчилгээнд ашиглаж, албан хаагчид гадуур явах ажлаа нэгтгэн аль болох бага зардлаар явж байна. 3 ажилтны зэрэг дэв, удаан жилийн нэмэгдлийг ҮСХорооноос тогтоосноор олгож байна. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг тогтмол оруулж, сар бүрийн 1-ний дотор санхүүгийн тайланг ҮСХороонд хүргүүлж , тулгалт хийлгэн баталгаажуулдаг. /тайланг хавсаргав/</p> <p>Мөн ҮСХорооноос ирүүлсэн даргын тушаал, үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж ажилласан. 2017 онд ҮСХорооны дарга болон Тамгын газрын даргын ирүүлсэн 6 албан даалгаврыг хугацаанд нь 100% биелүүлж тайлагнасан байна.</p>	30

<p>1.6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус хэлтсийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх 1.6.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус хэлтсийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. 1.6.2. Тухайн хөтөлбөрийн биелэлтийг аймгийн Засаг даргад тайлагнана.</p>	<p>Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах” бодлогын хүрээнд төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган хэмнэлтийг эрхэмлэн ажиллаж байна. Байгууллагын шилэн дансыг тогтмол хөтөлж, аймгийн Засаг даргын 01 албан даалгаврыг хяналтандаа аван, төсвийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж байна. тайланг хугацаанд нь гарган ЗДТГазарт хүргүүлж байна. /албан даалгаврын хэрэгжилтийн тайланг хавсаргав/</p>	<p>30</p>
<p>1.9. Хөрөнгө оруулалтын судалгааг зохион байгуулах; 1.9.1. Улирлын судалгааны мэдээллийг ҮСХ-ноос баталсан үзэл, баримтлал, маягт, зааврын дагуу ААНБ-аас үнэн зөв, бодитой гаргуулан авна. 1.9.2. Судалгааны үр дүн, мэдээг хугацаанд нь ҮСХ-нд дамжуулна.</p>	<p>Хөрөнгө оруулалтын судалгаанд хамрагдсан 4 аж ахуйн нэгж байгууллагад мэдээг графикт хугацаанд ирүүлэх тухай албан тоотыг Статистикийн тухай хуулийн холбогдох заалт бүхий зөвлөмж, графикийн хамт хүргүүлсэн. 2016 оны 4-р улирал болон 2017 оны 1,2,3-р улирлуудын мэдээг хүлээн авч, алдааг илрүүлэн, алдааны протоколыг хүргүүлж ажиллалаа. ҮСХорооноос 2017 оны 3-р улирлын 2 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээнд тодруулга ирснийг тухайн байгууллагаас авч, графикт хугацаанд нь ҮСХорооны төв серверт шивж дамжуулсан.</p>	<p>30</p>
<p>1.10. Үйлдвэрлэгчийн үнийн мэдээг /аж үйлдвэр, барилга, тээвэр, зочид буудал, зоогийн газар, холбоо/ цуглуулах; 1.10.1. ҮСХ-ноос баталсан удирдамж, зааврын дагуу мэдээллийг цуглуулна. 1.10.2. Үр дүн, мэдээг нэгтгэн боловсруулж, ҮСХ-нд дамжуулна.</p>	<p>Үйлдвэрлэгчийн үнийн мэдээллийг батлагдсан маягт, хуваарийн дагуу авч ҮСХороонд дамжуулсан.Тайлант хугацаанд аж үйлдвэрийн мэдээг 12, барилгын үнийн мэдээг 4 , зочид буудлын мэдээг 4, зоогийн газрын мэдээг 4, холбооны мэдээг 4 удаа авч нийтдээ 68 удаа 17 аж ахуйн нэгж байгууллагын мэдээг авсан байна. Мэдээг хоцроосон болон хамрагдаагүй аж ахуйн нэгж байхгүй болно.</p>	<p>30</p>
<p>1.11. Бичил уурхайн судалгааг зохион байгуулах; 1.11.1. ҮСХ-ноос баталсан үзэл, баримтлал, маягт, зааврын дагуу мэдээллийг цуглуулна. 1.11.2. Судалгааны үр дүн, мэдээг нэгтгэх, боловсруулан ҮСХ-нд дамжуулна.</p>	<p>Бичил уурхай эрхлэгч манай аймагт байхгүй боловч ҮСХорооноос өгсөн зөвлөмжийн дагуу жонш ангилан ялгагч, тээвэрлэгч зэрэг 4 цэгт ажиллаж байгаа 62 иргэнээс судалгаа авч нэгтгэн хүргүүлсэн. Бичил уурхайн судалгаанд хамрагдсан 62 иргэний асуулгын хуудсыг ҮСХорооны аж үйлдвэр хариуцсан ажилтанд 2017 оны 4 сарын 2-нд хүлээлгэн өгсөн байна.</p>	<p>30</p>

<p>1.13. Статистикийн мэдээлэл тархаалтын ажлыг өргөжүүлэх</p> <p>1.13.1. Мэдээлэл тархаалтын хуваарийг батлан мөрдөх ба эмхэтгэл, товхимол, танилцуулгын нэгдсэн бүртгэлтэй болсон байна.</p> <p>1.13.2. ҮСХ-ноос боловсруулсан хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судлах зааврын дагуу хэрэглэгчдийг бүртгэж, эргэх холбоотой ажиллана.</p> <p>1.13.3. Мэдээллээр үйлчлэх электрон самбарын болон статистикийн хэлтсийн вэб сайтын мэдээллийг тогтмол баяжуулж хэрэглэгчдэд үйлчлэх</p> <p>1.13.4. Статистикийн мэдээллийн танилцуулга, судалгаа, эмхэтгэл, нугалбар зэргийг тухай бүр хэвлэн тархаана.</p> <p>1.13.5. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан Статистикийн байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, мэдээлэл тархаалт, ашиглалтын талаар өргөн сурталчилна.</p> <p>1.13.6. Хэвлэмэл бүтээгдэхүүн, зурагт хуудас бэлтгэн тархааж, сурталчилгааны самбараар байнгын мэдээллийг тавьж сурталчилна.</p> <p>1.13.7. Хэрэглэгчидтэй байнгын уулзалт, сургалт, сурталчилгааг зохион байгуулна.</p>	<p>Мэдээлэл тархаалтын ажлыг цахимаар, хэвлэмэл хэлбэрээр, сургалтаар, сурталчилгаагаар, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тархааж байна. Байгууллагын “govisumber.nso.mn” цахим хуудсаар болон “Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс” Facebook хуудсаар байгууллагын үйл ажиллагааг болон аймаг, орон нутгийн статистикийн мэдээ, судалгааг нийтэд тархааж байна. Мэдээлэлийг сар бүрийн 10-15 –ны хооронд тархаан тайланг ҮСХороонд хүргүүлж байна. Шинээр гаргасан танилцуулга, ҮСХорооноос ирсэн эмхэтгэл, товхимолыг бүртгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Мэдээллийг дараах байдлаар тархаасан.</p> <p>1.Хэрэглэгчийн мэдээллийн санд шинээр 35 хэрэглэгч бүртгэж, давхардсан тоогоор 122 хэрэглэгчдэд 957 мэдээлэл өгч, бүх бүртгэгдсэн хэрэглэгч нарт сарын статистик мэдээ, мэдээллийг хүргүүлэв.</p> <p>2. Байгууллагын “govisumber.nso.mn” цахим хуудас, болон “Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс” Facebook хуудсаар байгууллагын үйл ажиллагаа, аймаг, орон нутгийн статистикийн мэдээ, судалгааг нийтэд сурталчлан тархааж байна. Хэлтсийн цахим хуудасны 8 цэс болон түүнд байрших 32 цэсийг шинээр зохион байгуулж хэрэглэгчдэд мэдээллийг хүртээмжтэй хялбар, ойлгомжтой хүргэх үүднээс бүх файлыг PDF, JPEG өргөтгөлтэйгээр байршуулсан.</p> <p>3. 2017 оны эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор -цахим хуудсанд 50 шинэ мэдээлэл, 116 PDF, 27 зурган файл -Фэйсбүүк болон пэйж хуудсанд 55 удаа мэдээлэл оруулж, 15 удаа шейр хийж, 260 зурган файл тус тус байршуулсан байна.</p> <p>4. Статистикийн танилцуулга, нугалбарыг цахимаар 1620, хэвлэмэлээр 162 , эдийн засгийн хуанлиг 150 гаруй, ҮСХорооноос ирүүлсэн болон хэлтсээс бэлтгэсэн 490 гаруй хэвлэмэл бүтээгдэхүүнийг тараасан байна.</p> <p>5. Улс, орон нутгийн сонин хэвлэлд 3 удаа мэдээлэл өгч, хэвлэлийн бага хурлыг 1 удаа зохион байгуулсан. Сарын нийгэм, эдийн засгийн мэдээллийг удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн дээр хийж, удирдлагуудад танилцуулж байна.</p> <p>6. Хүн ам, ХАА, Эрүүл мэнд, Хүн ам нийгмийн зарим салбарын сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр инфографик, 2016 оны Говьсүмбэр аймгийн хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтээр брошюр гаргаж, цахим болон цаасаар, хэлтсийн мэдээллийн самбарт байршуулан тархаан сурталчлан ажилласан.</p> <p>7. Нээлттэй хаалганы өдөрлөгийг Баянтал, Шивээговь сумдад хийж 250 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж 60 иргэнээс хэлтсийн үйл ажиллагааны талаар санал асуулга авлаа. Өдөрлөгийн үеэр “Сонирхолтой статистик” мэдээлэлийг 120 иргэнд, улс, аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр нугалбар бэлтгэн</p>	<p style="text-align: right;">28</p>
---	--	--------------------------------------

	тарааж, 30 иргэнд хуулийн зөвлөгөө өгсөн байна.	
2. “Анхан шатны мэдээллийн чанарт дээшлүүлэх” гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:	ахиц дэвшил гаргах, хяналт шалгалтыг өргөжүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг	
2.1. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах; 2.1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны ҮСХ-ны 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана. 2.1.2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гаргах ажлыг зохион байгуулна	Хэлтсийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүллээ.Төлөвлөгөөнд тусгагдсан 10 ажлын хэрэгжилт 100% байна. /төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав/ ХАСХОМ –ээ дарга, ахлах мэргэжилтэн нар хуулийн хугацаанд нь гаргаж,ҮСХорооны эрх бүхий албан тушаалтанд өгсөн. Авлигын талаархи сургалтыг хэлтсийн дарга 1 удаа, АЗДТГазрын хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Нэргүйцэцэгээр 1 удаа хийлгэлээ.	30
2.2. Эдийн засгийн статистикийн сар, улирал, жилийн мэдээ (ХАА, АҮ, Барилга, Тээвэр, Зочид буудал, Зоогийн газар, Худалдааны зэрэг)-ний хамралт, үнэн, бодит байдалд хийх хяналтыг бие даан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах; 2.2.1. Хэлтсийн даргын баталсан удирдамж, графикийг мөрдөнө. 2.2.2. Хяналт шалгалт, мониторингоор илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг тухай бүр авч байна	<u>Эдийн засгийн статистикийн мэдээг давхардсан тоогоор 118 ААНБ-аас авч, 397 удаагийн давтамжтайгаар авч ҮСХороонд дамжуулсан байна. Эдгээр мэдээний чанар, үнэн бодит байдлыг тухай бүрд нь хянаж 35 алдаа илрүүлж, алдааны протоколыг тухайн байгууллагад нь хүргүүлсэн байна.</u> Дотоод хяналт, улсын байцаагчийн шалгалтыг хэлтсийн даргын удирдамжаар Баянтал, Шивээговь сумдын “Чойр хайрхан”, “Шивээ сервис” ХХК-д хийж мэдээнүүдийн хамралт, үнэн, бодит байдал, баталгаажуулалтад хяналт хийж зөвлөгөө өгч, “Шивээ сервис” ХХК-д илэрсэн 3 зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлаг өгч зөрчлийг арилгуулсан. /тайланг хавсаргав/	30
2.3. Хүн ам, нийгмийн салбарын статистикийн мэдээ тайланг тогтоосон хугацаанд чанартай гаргаж ирүүлэх; 2.3.1. Батлагдсан маягт зааврын дагуу холбогдох мэдээллийг анхан шатны нэгжээс цуглуулж, нэгтгэх. Чанарын хяналт шалгалтыг хийж нэгтгэн дамжуулах. 2.3.2. Анхан шатны мэдээлэлд чанарын хяналт шалгалт хийж алдаагүй	НЗҮ-1,ХА-1,ХА-2,ХА-3 маягтаар мэдээллийг 1-2 удаагийн давтамжтайгаар 36 аж ахуйн нэгж байгууллагаас батлагдсан заавар, журмын дагуу мэдээг авч хугацаанд нь ҮСХороонд дамжуулсан. Дамжуулсан мэдээнд хяналт, шалгалтыг тухай бүрд нь хийж алдааг тодруулан шаардлагатай залруулгыг хийж, <u>55 алдаа илрүүлэн 36 алдааны протоколыг тухайн байгууллагад хүргүүлсэн.</u>	80

мэдээллийг дамжуулах.		
<p>2.4. ӨНЭЗС, АЗС, АХС-ны мэдээллийг цуглуулах боловсруулах, дамжуулах ажлыг чанартай зохион байгуулах;</p> <p>2.4.1. Баталсан үзэл баримтлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу мэдээллийн үнэн бодит байдлыг ханган цуглуулж, боловсруулна.</p>	<p>АХСудалгаанд 20 ТАШНэгжийн 240 өрх хамрагдсан байна. Түүвэрт сонгогдсон өрхүүдийг 100% хамруулж мэдээллийг аргачлалын дагуу авч, цаг хугацаанд нь дамжуулсан. Судалгаанд хамрагдсан өрхүүдээр багийн дарга нарын хамт явж өгсөн мэдээллийг нягтлан шалгаж, 28 тодруулга ирснийг тухай бүрд нь лавлан хариуг хугацаанд нь мэдэгдэж ажилласан байна.</p>	30
<p>2.5. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах;</p> <p>2.5.1. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах төлөвлөгөө боловсруулна.</p> <p>2.5.2. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг цахим хуудас, мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд сурталчилж ажиллана.</p> <p>2.5.3. Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулна.</p> <p>2.5.4. Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.</p> <p>2.5.5. Хэлтсийн хүний нөөцийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.</p> <p>2.5.6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, хэлтсийн төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.</p> <p>2.5.7. албан хаагчдад цаг үеийн байдал, хэрэгцээг харгалзан мэдээллийн цагийг хийнэ. /сар бүр/</p> <p>2.5.8. Хэлтэст ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох арга хэмжээг шуурхай авч</p>	<p>Засгийн газрын 2009.05.11-ний өдрийн 143 –р тогтоолын дагуу хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах 2017 оны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Үйл ажиллагааны ил тод байдлыг хэлтсийн govsumber.nso.mn цахим хуудас, мэдээллийн самбар, facebook хаягаар тогтмол мэдээлэл хийж байна.</p> <p>Нээлттэй хаалганы өдрийг 2 суманд зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, 2016-2017 оны улс, аймгийн нийгэм, эдийн засгийн байдлаар нугалбар хийн тараах, хуулийн зөвлөгөө өгөх, сонирхолтой статистикаар үйлчлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор 250 гаруй иргэнд үйлчилсэн.</p> <p>Хүний нөөцийн ил тод байдлыг журмын дагуу байгууллагын цахим болон мэдээллийн самбарт байрлуулахаас гадна Төрийн албаны хуулийн дагуу “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” Албан хаагчдыг ажлын байран дээр нь сургах, чадавхжуулах, бие биеэ орон ажиллах чадвартай болох зэрэгт анхаарч байгууллагын сургалтын хөтөлбөр батлан жил тутам төлөвлөгөө гарган ажиллаж байна. /төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав/</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, хэлтсийн төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд хүргэж байна.</p> <p>Мэдээллийн цагийг 14 хоног тутамд 1 удаа хийдэг бөгөөд 2017 онд нийтдээ 22 удаа хийж, орон нутгийн байгууллагуудын мэдээллийг болон цаг үеийн мэдээллийг хэлтсийн албан хаагчдад хийсэн байна.</p> <p>2017 оны эхний 11 сарын байдлаар санал, гомдол ирээгүй байна. Хэлтэст ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам гарган ажиллаж байна.</p>	28

ажиллана.		
2.6. Статистикийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих; 2.6.1. Бие дааж болон бусад байгууллагуудтай хамтран тооллого, судалгааны үнэн бодит байдалд хяналт шалгалтыг холбогдох эрх зүйн баримтын дагуу зохион байгуулна. 2.6.2. Хууль хяналтын байгууллагатай холбогдох чиглэлээр хамтран ажиллана.	Улсын байцаагчийн болон дотоод хяналт хариуцсан мэргэжилтний хяналт, шалгалтаас гадна гарфикийн дагуу ирж буй мэдээнүүдийг тухай бүрд нь хянан анхан шатны мэдээлэгч нарын гаргасан мэдээ, судалгааны үнэн бодит байдлыг нягтлан шалгаж, давхардсан тоогоор 72 байгууллагад алдааны протоколыг хүргүүлэн зөрчлийг арилгуулсан. Улсын байцаагч нарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн талаар аймгийн Прокурорын газраас сургалт авсан. Зөрчил хянан шийдвэрлэх явцад зөвлөгөө авч хамтран ажиллаж байна.	28
3. “Статистикийн дүн шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх” гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ		
3.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаар сарын танилцуулга бэлтгэх; 3.1.1. Тухайн сарын мэдээнд хамрагдсан бүх салбарын үзүүлэлтүүдээр танилцуулга бэлтгэнэ. 3.1.2. Танилцуулгыг ИТХ, ЗД, Тамгын газрын дэргэдэх хэлтэс албад болон бусад хэрэглэгчид, сумдад тархаасан байна.	“Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал” танилцуулгыг албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг үндэслэн дараа сарын 15-ны дотор гарган цахимаар болон хэвлэмэл байдлаар тархааж байна. Эхний 11 сарын байдлаар 10 танилцуулга гарган 800 гаруй хэрэглэгчид хүргэлээ. Аймаг, сумдын ИТХ, ЗД, Тамгын газрууд болон аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч нарт цахимаар болон хэвлэмэл байдлаар сар тутам хүргэдэг. Мөн хэлтсийн цахим хуудас, фейсбүүк хуудсаар дамжуулан нийтэд тархааж байна.	30
4. “Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах” гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
	тусгай захиалгат ажил үйлчилгээ	—
5. “Статистикийн салбарын чадавхийг бэхжүүлэх, төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах” гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:		
5.1. Статистикийн мэргэжлээр суралцаж буй хүний нөөцийн бүртгэл, судалгааг баяжуулсан байх;	Статистикийн чиглэлээр суралцаж, төгссөн 1 хүний мэдээллийг бүртгэж ҮСХороонд явуулаад байна. 2017 онд төгсөх оюутны судалгааг Говьсүмбэр аймгийн оюутны холбоогоор дамжуулан авсан боловч статистикийн мэргэжлээр төгсөж орон нутагт ирж ажиллах оюутан байхгүй байна.	28.

<p>5.2. Сургалт, семинар зохион байгуулах замаар боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх;</p> <p>5.2.1. ҮСХ болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинарт албан хаагчдыг хамруулна.</p> <p>5.2.2. Хэлтсийн хэмжээнд сургалт, семинарыг өөрсдийн нөөц бололцоогоор зохион байгуулна</p> <p>5.2.3. Статистикийн үйл ажиллагаатай холбоотой шинээр батлагдан гарсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, дүрэм, журмын талаарх сургалт, семинарыг зохион байгуулна</p> <p>5.2.4. Шинээр ажилд орж буй албан хаагчдад Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Үндэсний статистикийн хорооны хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмын талаар сургалт явуулна</p> <p>5.2.5. Статистикийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор иргэдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулна.</p> <p>5.2.6. Баг, хорооны түвшинд статистикийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалтыг зохион байгуулна.</p> <p>5.2.7. Ажилтнуудын хөрвөх чадварыг дээшлүүлэх зорилгоор сэлгэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>2017оны” Сургалтын төлөвлөгөө”-г гарган хэрэгжүүлж ажилласан. Сургалтыг хэлтсийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийх, гадны байгууллагаас албан хаагчдын сонирхлын дагуу сургалт авах, аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан сургалт хийхээр төлөвлөн ажилласан.</p> <p>1.Тайлант хугацаанд дээд газрын болон орон нутгийн байгууллагуудаас зохион байгуулсан 23 удаагийн сургалтад давхардсан тоогоор 51 хүн хамрагджээ.</p> <p>2. Хэлтсийн дотоод сургалтыг мэргэжилтнүүд өөрсдөө бэлтгэн, 10 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 40 хүн хамрагдсан байна. Энэ сургалтаар ажилтнуудын хөрвөх чадварыг сайжруулж, бие биеэ орлон ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. Шаардлагатай тохиолдолд бие биеэ орлон ажиллаж байна.</p> <p>3. 2017 онд 9 сургалт төлөвлөн зохион байгуулж давхардсан тоогоор 224 иргэнийг хамруулан сургалт хийж, Статистикийн тухай хууль, Байгууллагын болон, хувь хүний нууцын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар хичээл заасан.</p> <p>46 мэдээлэгч байгууллагад Статистикийн тухай хуулийн 9-р зүйл “Статистикийн мэдээлэгчийн эрх, үүрэг”-ийн талаарх зөвлөмжийг 1-р улиралд багтаан хүргүүлсэн.</p> <p>Мөн нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэд, АХС-д хамрагдсан өрхийн гишүүд, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, төрийн албан хаагчдад хуулийн нугалбар хийж хүргэх, сурталчлах ажлуудыг зохион байгуулж 3-4 удаагийн давтамжтайгаар 176 иргэнд зөвлөмж өгч,сурталчилгаа хийж ажилласан байна.</p> <p>Нийтдээ хуулийн талаархи сургалт, сурталчилгаа, зөвлөмжид давхардсан тоогоор 405 иргэн, ААНБ хамрагдсан байна.</p> <p>4. Статистикийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэрэглэгчдэд зориулан Шивээговь суманд “Статистикийн мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлага” сэдвээр хийж 20 иргэнийг хамруулсан. Мөн АЗДТГазрын албан хаагчдад “Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй” сэдэвт сургалтыг хийж 17 хүн хамруулсан байна.</p> <p>5.Багийн Засаг дарга нар болон статистик хариуцсан мэргэжилтнүүд,бүртгэлийн ажилтнуудад 2 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 51 хүнийг хамруулсан.</p>	<p>М</p> <p>30</p>
<p>5.3. Цаг үеийн шаардлагаар ҮСХ-ноос эдийн засгийн статистик болон хүн ам,</p>	<p>1. Улсын хэмжээнд анх удаагаа зохион байгуулсан Зөвлөлдөх санал асуулгын 1-р шатны судалгаанд Шивээговь сумын 10 иргэнийг хамруулан судалгааг</p>	

<p>нийгмийн статистикийн чиглэлээр нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь цуглуулж дамжуулах</p> <p>5.3.1. Маягт, заавар аргачлалын дагуу мэдээллийг цуглуулна.</p> <p>5.3.2. Мэдээллийг тогтоосон хугацаанд дамжуулна.</p>	<p>ҮСХороонд товлосон хугацаанд нь дамжуулсан. 2-р шатны асуулгад 5 иргэнийг Улаанбаатар хотод болсон анхдугаар санал асуулгад аваачиж бүрэн хамруулсан.</p> <p>2. БТСпортын тооллого- хийгдэж байна. /2018 оны 1-р сарын сард тооллого дуусна.</p> <p>3. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцооны суурь мэдээллийг шинэчлэх судалгаа 12-р сарын 04-18-ны өдрүүдэд хийгдэж 2 ААНБ хамруулна. Ажил хийгдэж байна.</p>	<p style="text-align: right;"><u>30</u></p>
<p>5.4. Шинээр байгуулагдсан үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж, шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний мэдээллийг тухай бүр албан ёсны мэдээлэлд хамруулна;</p> <p>5.4.1. Улирал бүр улсын бүртгэлийн хэлтэс, сумдын татварын байцаагч нартай хамтарч шинээр байгуулагдсан болон регистрийн санд бүртгэгдээгүй аж ахуйн нэгжийг тогтоож маягт, үзүүлэлтийн дагуу бүртгэн ҮСХ-нд мэдээлнэ.</p>	<p>Аймгийн хэмжээнд 2017 онд 30 аж ахуйн нэгж шинээр байгуулагдсаныг бүртгэн мэдээллийг ҮСХороонд дамжуулсан.</p>	<p style="text-align: right;"><u>30</u></p>
<p>5.5. Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд амьдралын судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх</p> <p>5.5.1. Судалгааг зохион байгуулахад орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлж ажиллана.</p>	<p>Тус судалгаанд 19 нэгжийн 285 өрх сонгогдож, Сүмбэр сумын 195, Шивээговь сумын 60, Баянтал сумын 30 өрхийг тус тус хамруулсан. Аймгийн хэмжээнд судалгааны 2 баг ирж ажилласан бөгөөд судалгааны багт дэмжлэг үзүүлэн нийт хамрагдах айлуудыг 100% хамруулж дэмжлэг үзүүлэн ажилласан.</p>	<p style="text-align: right;"><u>30</u></p>
<p>5.6. Статистикийн бизнес регистрийн сангийн чанарыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх;</p> <p>5.6.1. Статистикийн бизнес регистрийн сангийн чанарт анхаарч ажиллана.</p>	<p>Бизнес регистрийн санд 431 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгааг 2 удаагийн давтамжтайгаар жилийн эцсийн мэдээний тодруулгын болон БР-ийн программд давхардсан тоогоор 800 гаруй ААНБ-ын мэдээллийг шинэчилсэн.</p>	<p style="text-align: right;"><u>30</u></p>
<p>5.8. Архивын баримтын хадгалалт</p>	<p>5.8.1; Хэлтсийн даргын баталсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний</p>	

<p>хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллах; 5.8.1; Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p>	<p>дагуу архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт хийж илэрсэн зөрчлийг аймгийн архивын тасгаас зөвлөгөө аван цэгцэлсэн. Мэргэжилтэн бүр өөрийн хариуцсан салбарын материалыг архивлан 2017 оны 1-р улиралд багтаан архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.</p>	<p>23</p>
<p>5.9. Албан хаагчдын ажиллах таатай орчин, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 5.9.1.Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс биеийн тамир, спорт, соёл, олон нийтийн арга хэмжээний төлөвлөгөө гарган зохион байгуулна. 5.9.2.Хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулна. 5.9.3.Албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай эд хогшил, техник хэрэгсэлээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p>	<p>Албан хаагчдын “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу 2017 оны төлөвлөгөөг 18 заалт бүхий хөтөлбөр гарган ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилт 94,4% байна. Албан хаагчдын амралт, чөлөөт цагаараа бие бялдараа хөгжүүлэх эрүүл мэндээ хамгаалах олон нийтийн арга хэмжээнд хамт олноороо оролцох бололцоогоор хангаж хамт олны аялал хийсэн. Мөн сонирхлын дагуу бүжгийн дугуйланд хамрагдан хичээллэж байна. Хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын байрны дасгал хөдөлгөөнийг ЭМГазрын мэргэжилтнээр заалган хийж байна. Мөн хүнсний аюулгүй байдлын тухай сургалтад хамрагдлаа. 2 хүнийг үзлэг шинжилгээнд үнэгүй хамруулах эрх авч хамруулсан. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор даргын өрөөнд урсгал засвар хийсэн. ҮСХорооноос нэн шаардлагатай байгаа принтер, таблет зэргийг шийдвэрлүүлэн авсан.</p>	<p>25</p>
<p>Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>		
<p>29.7</p>		
<p>ХОЁР. ТУСГАЙ ЗАХИАЛГАТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ :</p>		
<p>Арга хэмжээ-1.2. “Монгол Улсы статистикийн салбарыг 2017-2020 он хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг орс нутгийн түвшинд хэрэгжүүлэх 1.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ажиллана. 1.2.2. Хэрэгжилтийг ҮСХ-нд тайлагнана.</p>	<p>“Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдаж 11-р сарын 13-14- нд болсон үндэсний чуулган дээр албан ёсоор танилцуулагдлаа. 2018 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллах чиглэл ҮСХорооноос өгсөн байна.</p>	<p>30</p>
<p>1.4.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах;</p>	<p>1-р улиралд багтаан өмч хамгаалах комисс байгууллагын өмчийг тоолон бүртгэсэн байна. Байгууллагын хэрэгцээ шаардлага хангахгүй техник</p>	<p>40</p>

<p>1.4.1. Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн болон биет хөрөнгө, үнэт цаасыг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, өмч хөрөнгийн тооллого явуулна.</p> <p>1.4.2. 2017 оны төсвийн төлөвлөлт, төсвийн уялдаа холбоог хангаж ажиллана.</p> <p>1.4.3. Жилийн эцсийн 2016 оны санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитаар баталгаажуулна.</p> <p>1.4.4. 2018 оны төсвийн төслийг боловсруулж, ҮСХороонд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.</p> <p>1.4.5. Төсөв, зардлыг бууруулах чиглэлээр тодорхой ажил санаачлан зохион байгуулна</p>	<p>хэрэгслийн жагсаалтыг гарган ҮСХороонд хүргүүлсэн. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өдөр тутмын үйл ажиллагааг төсвийн хүрээнд зохион байгуулж, төсвийн хэмнэлтийг эрхэмлэн батлагдсан орон тоо, цалин сангийн хязгаарт багтаан үйл ажиллагаагаа эрхэлж байна. Дотоод албан томилолтын замын зардлыг нийтийн тээврийн жишгээр олгож,суудлын авто машиныг нэн шаардлагатай ажил үйлчилгээнд ашиглаж, албан хаагчид гадуур явах ажлаа нэгтгэн аль болох бага зардлаар явж байна. 3 ажилтны зэрэг дэв, удаан жилийн нэмэгдлийг ҮСХорооноос тогтоосноор олгож байна.Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг тогтмол оруулж, сар бүрийн 1-ний дотор санхүүгийн тайланг ҮСХороонд хүргүүлж, тулгалт хийлгэн баталгаажуулдаг</p> <p>2017 онд цалин сан хүрэлцээгүй батлагдсан байсан учир ҮСХороонд хүсэлт тавьж шийдвэрлүүлснээр 2017 оны 2-р сараас эхлэн өр үүсгэхгүй ажиллаж байна.</p> <p>2016 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж ҮСХ-д хүргүүлсэн ба 2016 оны жилийн эцэст үүссэн НДШ, ХАОАТ-ын өрийг 2017 онд барагдуулж ажиллав. 2018 оны төсвийн төслийг ҮСХорооноос тогтоосон хугацаанд гарган хүргүүлэв.</p> <p>Албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулан гадуур явах ажлыг хамтруулан ажилласнаар унааны зардал хэмнэгдэж шатахууны өр үүсгэхгүй байна. Баг, сумын ажилтнууд, дарга нартай цахимаар мэдээллээ солилцож цаг хугацаа, шуудангийн зардлыг батлагдсан төсөвт багтааж ажилласан.</p>	
<p>1.5. ҮСХ-ны даргын 2016 оны А/79 тоот тушаалаар баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар цуглуулж, дамжуулах;</p> <p>1.5.1. Улсын хэмжээний 7 тооллого, судалгаа болон албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээ, тайланг маягтын дагуу мэдээллийг цуглуулж, дамжуулна.</p> <p>1.5.2. Мэдээний маягт, заавар, аргачлалыг сум, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, мэдээ цуглуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>ҮСХ-ны даргын 2016 оны А/79 тоот тушаалаар баталсан мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний 7 судалгаа хийгдэхээс ӨНЭЗСудалгаа 2017 онд манай аймагт хийгдэхгүй бөгөөд АХСудалгааг 12 удаа, ББӨ-1 судалгааг 1 удаа, ХО-1 судалгааг 1 удаа, ЭЭМАТуршлагын судалгаа, хагас бүтэн жилийн мал тооллого зэргийг зохион байгуулсан байна. Мөн 53 төрлийн мэдээг 249 байгууллагаас авч хугацаанд нь дамжуулсан.</p> <p>Мэдээний маягт, заавар, аргачлалыг 2017 оны 1-р улиралд багтаан сум, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн. 3 суманд мэдээний маягтаар каталоги хийн хүргүүллээ.</p> <p>Ажилтан бүр цуглуулсан мэдээллийг маягт бүрээр шалган хүлээн авч алдааны протоколыг үйлдэн холбогдох байгууллагуудад хүргүүлж залруулга хийн ажиллаж байна. Тайлант хугацаанд 72 байгууллагад алдааны протоколыг хүргүүлэн зөрчлийг арилгуулсан.</p> <p>Боловсруулалт хийх шаардлагатай мэдээллийг салбар бүрээр нэгтгэн</p>	<p>40</p>

<p>1.5.3. Ажилтан бүр цуглуулсан мэдээллийг маягт бүрээр нэг бүрчлэн шалгаж, алдааг засаж, протокол хөтөлнө.</p> <p>1.5.4. Мэдээллийг салбар бүрээр, программаар нэгтгэн боловсруулна.</p> <p>1.5.5. Мэдээллийг электрон хэлбэрээр графикт хугацаанд нь Ерөнхий газарт дамжуулна.</p> <p>1.5.6. Маягт бүрээр мэдээ тайланг цуглуулсан, дамжуулсан талаарх бүртгэлийг хөтөлсөн байна.</p>	<p>программд оруулан нэгтгэж байгаа бөгөөд маягт, аргачлал заавар зөрчсөн зөрчил гаргалгүй ажиллаж, мэдээний ирцийн бүртгэл, протоколийн бүртгэл зэргийг хийж хэвшээд байна.</p> <p>Мэдээллийг электрон хэлбэрээр графикт хугацаанд нь ҮСХороонд хүргүүлж байна. Хугацаа хоцорсон мэдээ байхгүй, мэргэжилтэн бүр мэдээ тайлангаа зөвшөөрөгдсөн маягтын дагуу цуглуулж, хяналт хийн ҮСХ – д дамжуулсан талаарх бүртгэлийг хөтөлж байна.</p>	
<p>1.7. Аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлагын хэрэгцээнд шаардлагатай захиргааны статистикийн мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийх;</p> <p>1.7.1. Мэдээллийг 12 маягтын дагуу мэдээлэгчдээс цуглуулна.</p> <p>1.7.2. Мэдээллийг боловсруулан хянаж, нэгтгэн эмхэтгэл, танилцуулгаар тархаана.</p>	<p>1.7.1; Аймгийн төр захиргааны байгууллагуудын удирдлагын хэрэгцээнд шаардлагатай захиргааны статистикийн мэдээллийн маягтыг шинэчлэн боловсруулж мэдээ авахдаа ашиглаж байна. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг үндэслэн сар бүрийн "Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал" танилцуулгыг гарган төр захиргааны байгууллагуудад болон хэрэглэгч нартаа цахимаар болон хэвлэмэл байдлаар хүргүүлж байна. 2017 онд 11 сарын байдлаар 10 танилцуулга гарган 800 орчим хэрэглэгчид цахимаар болон хэвлэмэл байдлаар гарган хүргүүлсэн.</p>	<p style="text-align: right;">/10</p>
<p>1.12. Мал тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулах;</p> <p>1.12.1. Малын хагас, бүтэн жилийн тооллогыг явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.</p> <p>1.12.2. Мал тооллогыг сумдад зохион байгуулах ажилтнуудын сургалт, семинар /аргачлал болон программ зэрэг/-ыг явуулах.</p> <p>1.12.3. Малын тооллогыг оновчтой зохион багуулах мэргэжлийн удирдлагаар хангана.</p> <p>1.12.4. Мал тооллогын дүн мэдээг өрх</p>	<p>2017 оны хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 6 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд аймгийн Засаг даргын 2017 оны А/169 тоот захирамжаар ЗД-ын орлогч даргаар ахлуулсан комисс байгуулагдаж ажилласан. Түүвэр судалгаанд аймгийн нийт малтай өрхийн 16 хувь буюу 241 өрх, аж ахуйн нэгж байгууллага түүвэрлэгдэж 100 хувь хамрагдлаа. Судалгааны үр дүнг графикт хугацаанд нь ҮСХороонд дамжуулсан. Мөн судалгааны хяналтын тооллогыг 06 дугаар сарын 14-19-ны өдрүүдэд зохион байгуулж 3 сумын 24 өрх буюу судалгаанд түүвэрлэгдсэн өрхийн 10 хувийг хамруулан шалгалаа. Шалгалтаар их хэмжээгээр зөрүүтэй байсан өрхийн малыг дахин тоолж баталгаажуулах ажлыг хийж залруулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2017.11.28-ны өдрийн А/316 тоот захирамжаар аймгийн комиссыг байгуулж тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангуулаад байна.</p>	<p style="text-align: right;">/10</p>

<p>бүрээр онлайнгаар шивэх бэлтгэл зохион байгуулалтыг хангах.</p>	<p>Аймгийн комиссоос тооллогын сургалтыг 11-р сарын 29-нд зохион байгуулж, 3 сумын 35 албан хаагч хамрагдлаа. Мөн мал тооллогын маягтын захиалга авч, хэвлэн хүргүүлсэн байна. Тооллого 12-р сарын 07-17-ны өдрүүдэд зохион байгуулагдана. / дүнг 2017 оны 27-ны өдрөөс хойш нийтэд мэдээлнэ/</p>	
<p>2.7. Хэлтсийн дотоод үйл ажиллагаанд хяналт тавих; 2.7.1 Албан хаагчдын сахилга хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлнэ. 2.7.2. Албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн эргэлт, шийдвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана.</p>	<p>Хэлтсийн дотоод хяналтын журмыг 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/01 тоот тушаалаар батлан ахлах мэргэжилтэн хариуцан ажиллаж байна. Хэлтсийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт хийсэн. Хэлтсийн хэвийн үйл ажиллагааг хангах, бие биеэсээ суралцах, мэдлэг мэдээллээ хуваалцах зорилгоор дотоод сургалтуудыг мэргэжилтэн бүр зохион байгуулж 100% хамрагдсан. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архив, ил тод байдалд илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулан ажиллалаа. Аймгийн архивын тасгаас албан бичгийн стандартаар сургалт авч, хэлтсээс гарч байгаа баримт бичгийг стандартад нийцүүлж байна.</p>	<p>40</p>
<p>3.2. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хэрэглэгчдэд зайлшгүй тархах 4 танилцуулгыг бэлтгэх; 3.2.1. Шаардлагатай тоон мэдээллийг бэлтгэн холбогдох зэрэгцүүлэлт, харьцуулалт хийх судалгаа гаргах ба танилцуулга цахим болон хэвлэмэл байдлаар тархагдана.</p>	<p>Аймгийн “Хөдөө аж ахуйн танилцуулга”, “Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтийн төлөв байдал”, “Ажил эрхлэлтийн байдал” “Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын байдал” зэрэг 4 танилцуулгыг гарган цахимаар болон хэвлэмэлээр тархаасан. Цахимаар 122 хэрэглэгчид, хэвлэмэлээр аймаг, сумын ЗДТГ-аар ИТХурлын байгууллагуудад хүргүүлсэн.</p>	<p>35</p>
<p>4.1. Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах 4.1.1;Хэрэглэгчдэд зориулсан сургалтыг нутгийн төр, захиргааны байгууллагын ажилтнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд болон иргэдэд зохион байгуулна. 4.1.2; Сургалтын тайланг баримжуулан ҮСХ-нд хүргүүлнэ.</p>	<p>Хэрэглэгчдэд зориулсан сургалтыг аймгийн ЗДТГ-ын бодлогын мэргэжилтнүүдэд зориулж “Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй” сэдвээр хийж 17, Шивээговь суманд “Статистикийн мэдээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлага” сэдвээр хийж 20, “Статистикийн боловсрол” сэдвээр ПТК-ийн 30 оюутан, Шивээговь сумын ЕБС-ийн 40 сурагчийг тус тус хамруулсан байна. Сургалт, сурталчилгаа, мэдээлэл тархаалтын тайланг баримтжуулан шалгуур үзүүлэлтэд заасан хугацаанд ҮСХ-ны холбогдох ажилтанд цахимаар хүргүүлсэн.</p>	<p>40</p>

<p>5.7. “Хүн ам, өрх”-ийн мэдээллийн сангийн баяжилтыг сумын түвшинд сайжруулан үйл ажиллагаандаа ашиглах; 5.7.1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг сум, багийн түвшинд баяжуулахад хяналт тавин ажиллана. 5.7.2. Мэдээллийн сангийн нууцлалыг ханган үйл ажиллагаандаа ашиглах ажлыг өргөжүүлнэ.</p>	<p>ХАӨМСангийн 1402 алдааг илрүүлэн 26 болгон бууруулсан. Ургийн овгийн 376 алдааг ҮСХороо, ОӨУБГазартай хамтран залруулсан. Нас барсан, овог сольсон, регистрийн дугаар зэргийн тодруулгыг ҮСХороонд мэдэгдэж 19 удаа засуулсан. Шилжилт батлах, хүлээгдэж буй шилжилтийн нэгтгэлийг 3 удаа хийж, 30-аас дээш хоногоор хүлээгдэж буй шилжилтийн 177 мэдээллийг холбогдох сум, баг, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнуудад мэдэгдэж баталгаажуулав. Мөн сум, багийн Засаг дарга нарын facebook групп, чат групп нээн алдааны протокол болон өдөр тутмын зааварчилгааг өгч ажилласан. Орон нутгийн сонгуулийн үр дүнгээр солигдсон 6 багийн Засаг дарга нарт ХАӨМС-д нэвтрэх эрхийг сольж өгсөн. Мэдээллийн сангийн нууцлалыг хангах талаар багийн дарга нар болон статистик хариуцсан төрийн сангийн мэргэжилтнүүдэд заавар өгч, тэмдэглэл үйлдэн ажилласан байна.</p>	<p style="text-align: right;">40</p>
<p>Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>		<p>38,3</p>

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Манлайллын зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
<p>1.Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын</p>	<p>Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн ашиг, сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гарган ҮСХорооны эрх бүхий албан</p>	

<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт-1: Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхолын зөрчил, авлигаас ангид байх талаархи холбогдох хууль, тогтоомжийг судлан биелүүлэх</p>	<p>тушаалтанд хүргүүлсэн. Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхолын зөрчил, авлигаас ангид байх талаархи холбогдох хууль, тогтоомжийг судлан биелүүлж, өөрийн хэлтсийн хамт олонд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 1 удаа сургалт зохион байгуулсан. Байгууллагын албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулахаар байгууллагын сургалтын төлөвлөгөөнд хүний эрхийн тухай, авлига, ашиг, сонирхлын тухай болон бусад хуулийн сургалтуудыг тусган холбогдох байгууллагуудыг урин хамтарч ажилласан.</p>	<p><u>30</u></p>
<p>2. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил, тод байлган, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг орон нийтэд хүргэх</p>	<p>Байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний талаар цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэж, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна. байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн ил тод байдлын талаархи мэдээллийг тогтмол байршуулдаг.</p>	<p><u>30</u></p>
<p>3. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт-1: төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын ил тод байдлыг хангах, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв тайлагнах</p>	<p>а/ Байгууллагын санхүүгийн тайланг мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд ил тод байлган шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төсвийн хэмнэлтийг эрхэмлэн батлагдсан орон тоо, цалин сангийн хязгаарт багтаан үйл ажиллагаагаа эрхэлж байна. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг тогтмол оруулж, сар бүрийн 1-ний дотор санхүүгийн тайланг ҮСХороонд хүргүүлж, тулгалт хийлгэн баталгаажуулдаг. б/ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, сар бүрийн санхүүгийн мэдээ, тайланг хугацаанд нь ҮСХороонд тайлагнасан.</p>	<p><u>30</u></p>
<p>4. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт-1: байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах, эд хөрөнгийн тооллого, тооцоо, бүртгэлийг үнэн зөв гаргах</p>	<p>а/ Байгууллагын эд хөрөнгийг 2017 оны 1-р улиралд тоолж хугацаанд нь дээд шатны байгууллагадаа тайлагнасан. б/ Албан хаагч бүрт эзэмшиж буй эд хөрөнгийг хариуцуулан карт хөтөлж байна. Сангийн яамны Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хийсэн шалгалтаар 98% буюу А үнэлэгдсэн.</p>	<p><u>30</u></p>
<p>5. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар: зорилт-1: төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцлийг сайжруулах</p>	<p>а/ Хэлтсийн хүний нөөцийн мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. Албан хаагчдаа сургах сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Давхардсан тоогоор дотоод болон дээд газар, орон нутгаас зохион байгуулсан сургалтад 1 хүн 3-4 удаа хамрагдсан байна. б/ Ажлын байрны сургалтын төлөвлөгөөг батлан 7 хоног бүрийн Даваа гаригт зохион байгуулж хэвшээд байна.</p>	<p><u>30</u></p>

	б/ ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу 2017 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган 18 ажил төлөвлөснөөс 17 ажил хэрэгжүүлсэн байна.	
Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО		30.



Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Л.Мөнгөнцэцэг

ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:

Төсвийн ерөнхийлөн захирагч:

Аймгийн Засаг дарга

Г.Батсуурь

